

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 13 ДУГААР ХУРАЛ**

2020 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн 12 цаг 30 минутад эхэлж, мөн өдрийн 17 цаг 10 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 04 цаг 40 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Алтай сумын Эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн ахмад ажилтан С.Адъяаагийн, Жаргалант сумын Прогрессийн сургуулийн урд уулзвараас бага голын гүүр хүртэлх гудамжыг Байгаль орчны ахмад ажилтан Ж.Хайдавын нэрэмжит тус тус болгох саналыг дэмжих тухай	Алтай сумын Эрүүл мэндийн төвийг эрүүл мэндийн ахмад ажилтан С.Адъяаагийн, Жаргалант сумын Прогресс дунд сургуулийн урд уулзвараас бага голын гүүр хүртэлх гудамжыг Байгаль орчны ахмад ажилтан Ж.Хайдавын нэрэмжит тус тус болгох саналыг хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
2	Алсын хараа 2050 хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнах ажлын тухай	Алсын хараа 2050 хөгжлийн хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хэрэгжилтийг тайлагнах явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
3	Дуут сумын Шивэр багийн Бүргэдтэй хайрхан, Ар хужирт, Хар чулуут гэсэн 30332,50 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай	Дуут сумын Шивэр багийн Бүргэдтэй хайрхан, Ар хужирт, Хар чулуут гэсэн 30332,50 га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах тухай саналыг дэмжиж аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
4	“Жаргалант агропарк” орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай	“Жаргалант агропарк” орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар байгуулах тухай төслийг дэмжиж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболдод үүрэг болгов.
5	Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах тухай	Аймгийн 2020 оны төсөвт нэмэлт өөрчлөлт оруулж батлах тухай төслийг дэмжин хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү,

		төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд үүрэг болгов.
6	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй гүйцэтгэлийн тухай	Засаг даргын нөөц хөрөнгийн хүлээгдэж буй 5.404.800 төгрөгийг аймгийн Засаг даргын нөөцөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Ч.Багдалд, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Д.Энхболд нарт тус тус үүрэг болгов.
7	2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай	2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай төслийг дэмжин хэлэлцэх явцад гарсан саналыг тусгаж Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанаар хэлэлцүүлэхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга Э.Дөлбадралд үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР